

НУУЦ ХАДГАЛАХ, ХАМГААЛАХ ТУХАЙ БАТАЛГААНЫ ГЭРЭЭ

201... оныдүгээр сарын-ны өдөр
хот

№

Улаанбаатар

Нууц хадгалах, хамгаалах тухай баталгааны гэрээ /цаашид “Гэрээ” гэх/-г нэг талаас "....." ХХК, түүнийг төлөөлж гүйцэтгэх захирал, нөгөө талаас "....." ХХК, түүнийг төлөөлж гүйцэтгэх захирал /...../ (Мэдээллийн өгч, авч байгаа эсэхээс хамаарч “Мэдээлэл хүлээн авагч”, “Мэдээлэл өгөгч” гэх) /цаашид хамтад нь “талууд” гэх/ нар нь МУ-ын Иргэний хууль, Байгууллагын нууцийн тухай хууль, Хувь хүний нууцын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийг үндэслэн, харилцан тохиролцож дараах нөхцөлөөр байгуулав.

НЭГ. ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- 1.1. Талууд харилцан ашигтайгаар бизнесийн үйл ажиллагааг явуулах, ажил хэргийн нэр хүнд болон хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилготой бөгөөд энэхүү бизнесийн хамтын ажиллагааны явцад харилцан солилцсон мэдээ, мэдээллийн нууцыг хугацаагүйгээр хадгалахтай холбогдсон талуудын хооронд үүсэх харилцаа, эдлэх эрх, хүлээх үүрэг, хариуцлагыг зохицуулахад энэхүү гэрээний зорилго оршино.
- 1.2. Талууд энэхүү гэрээнд заасан бизнесийн болон бусад нууцад хамаарах мэдээ, мэдээлэл, баримт бичиг, биет зүйлий хадгалах, хамгаалах, нөгөө талын албан ёсны бичгийн зөвшөөрөлгүйгээр бусдад задруулахгүй, ашиглуулахгүй байх, нууцад хамаарах мэдээ мэдээлэлд хүрэх арга замыг хувь хүн болон хуулийн этгээдэд санаатай болон санаандгүй байдлаар задруулахгүй байх үүрийг харилцан хугацаагүй хүлээнэ.
- 1.3. “.....

ХОЁР. ТАЛУУДЫН ЭРХ, ҮҮРЭГ

- 2.1. Талууд гэрээ болон гэрээний эрх, үүрэг, шаардах эрхийг нөгөө талын бичгийн албан ёсны зөвшөөрөлгүйгээр гуравдагч этгээдэд шилжүүлэхийг хориглоно.
- 2.2. Мэдээллийг хадгалах хэлбэр, арга нь цаасан дээр хэвлэсэн, эсвэл электрон хэлбэртэй байгаа тухайлбал бүх төрлийн зориулалтын хадгалагч /CD, флаш г.м/, компьютер, мэдээллийн сүлжээ, серверт хадгалагдаж байгаа, эсвэл дуу дүрс бичлэгийн аппарат, бусад боломжтой бүх арга хэлбэр байж болох ба мэдээ, мэдээллийн нууцыг тухай бүр тохирсон арга, хэлбэрээр чандлан хамгаалах, задруулахгүй байх бүх арга хэмжээг авах үүрэгтэй.
- 2.3. Мэдээлэл хүлээн авагч талын нууц мэдээ, мэдээллийг хадгалах стандарт нь өөрийн байгууллагад мөрддөг журам, стандартаас доогуур байж болохгүй.
- 2.4. Шаардлагатай тохиолдолд "Мэдээлэл өгөгч" нь нууц мэдээ, мэдээлэл дээр монгол эсхүл англи хэлээр "НУУЦ" эсхүл "CONFIDENTIAL" гэсэн дардас дарах буюу бичвэр үйлдэнэ.
- 2.5. "Мэдээлэл өгөгч"-өөс "Мэдээлэл хүлээн авагч"-д өгсөн аливаа хэлбэрийн бүх мэдээлэл нь "Мэдээлэл өгөгч"-ийн өмч бөгөөд тэдгээрийн хуулбар болон баримт сэлтийг "Мэдээлэл өгөгч"-д түүний шаардлагын үндсэн дээр баримтаар буцаан өгөх буюу "Мэдээлэл өгөгч"-ийн үзэмжээр устгана. Энэ тухай баримтад талууд гарын үсэг зурж баталгаажуулна.
- 2.6.

Үргэлжлэл бий ...